

"ТӨВӨД СУДЛАЛ"
сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүллээ
хэвлүүлэхийг урьж байна

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлдэг эрдэм шинжилгээний сэтгүүлийн нэг "Төвөд судлал" нь Олон улсын эрх бүхий ISSN 2308-2828 дугаартай, төвөд хэлт утга зохиол, сурвалж судлалын эрдэм шинжилгээний сэтгүүл болно.

Тус сэтгүүлийн XIII боть өгүүллээ авч эхэлсэн тул төвөд хэлт утга зохиол, төвөд сурвалж судлал, буддын судлалаар судалгаа хийдэг эрдэмтэн судлаач та бүхнийг “ТӨВӨД СУДЛАЛ” сэтгүүлийн 2024 оны дугаарт сүүлийн үед хийж буй судалгааны бүтээлээсээ хэвлэн нийтлүүлнэ үү хэмээн урьж байна.

Өгүүлэл хүлээн авах: 2024.05.24 хүртэл
Редакцын зөвлөл хянах: 2024.05.31 хүртэл
Сэтгүүлд тэнцсэн эсэхийг мэдэгдэх: 2024.06.07 хүртэл
Өгүүллийг засах: 2024.06.28 хүртэл
Сэтгүүлийг хэвлэлд бэлтгэх, хэвлүүлэх: 2024.08.02 хүртэл
Өгүүлэл хүлээн авах цахим хаяг: bayartuyab@mas.ac.mn

ӨГҮҮЛЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Ерөнхий шаардлага:

- Шинжлэх ухааны үндэслэлтэй
- Урьд өмнө өөр хэвлэлд нийтлээгүй
- Сэтгүүлд өгүүлэл хүлээн авах шаардлагыг чанд баримтлан бичсэн байх

Өгүүллийн бүтэц:

- Өгүүллийн нэр (Англи орчуулгын хамт)
- Зохиогчийн овог нэр (Англи)
- Зохиогчийн харьяалагдах байгууллага, албан тушаал, зэрэг цол (Англи орчуулгын хамт)
- Хураангуй (100-200 үгтэй, англи, монгол хэлээр бичсэн байх)
- Түлхүүр үг (англи, монгол хэлээр бичсэн байх)
- 1. Удиртгал
- 2. Судалгааны арга, хэрэглэгдэхүүн
- 3. Судалгааны хэсэг (Гарчгийг бичсэн байх)
- 4. Судалгааны үр дүн (Хэлэлцүүлэг)
- 5. Дүгнэлт
- Ном зүй
- Талархал (хэрэв шаардлагатай бол)
- Хавсралт (хэрэв шаардлагатай бол)

Өгүүллийн хэлбэр:

Цаасны хэмжээ	A4, хуудасны тоо 8-аас доошгүй
Цаасны хүрээ	Бүх талаас 25мм (дээд, доод, баруун, зүүн)

Фонт	Times New Roman, үсгийн хэмжээ 11-pt.
Мөр хоорондын зай	1.15 (space)
Гарчиг	Гарчиг болон судлаачийн мэдээллийг эхний хуудсанд байрлуулна. Өгүүллийн нэрийг том үсгээр, тод хараар бичиж, дор нь баруун талд зохиогчийн овог нэр, улс, хот, ажил (сургууль, байгууллага)-ын нэрийг бичнэ.
Үндсэн болон дэд бүлэг гарчиг	Үндсэн бүлгүүдийн нэрийг хуудасны төвд том үсгээр бичнэ. Дэд бүлгийн гарчиг нь хуудасны зүүн талд байрлах бөгөөд том эсвэл жижиг үсгээр бичиж болно. Гарчгуудыг 1, 1.1, 1.1.1 гэх мэтээр дугаарлана.
Хүснэгт, зураг	Хүснэгт болон зураг нь нэгдмэл дараалсан дугаартай, агуулгаа тодорхойлсон нэртэй байна. Хүснэгтийн нэрийг дээр нь, зургийн нэрийг доор нь голлуулан бичнэ.
Зүүлт тайлбар (footnote)	Үгийн тайлбар, засвар, залруулга, нэмж судлах материалуудын талаарх мэдээллийг дэлгэрэнгүй өгөх зэрэг тохиолдолд хэрэглэж болно.

Жич: *Өгүүллийн бүтцийн загварт 6th edition of the American Psychological Association (APA)-г баримтална.*

Эшлэлд дараах загварыг баримтална:

1. Шууд эшлэхдээ:

40-с доош үгтэй бол эшлэлийг хашилтад бичиж, хаалтад зохиогчийн нэр, он, хуудсыг бичнэ. Жишээ нь: “Монгол бичиг бол ухааран бодож бичихийг дүрэм журам нь шаарддаг” (Дашцэдэн, 2004: 73).

Хэрэв 40-өөс дээш үгтэй бичвэр бол догол мөрөөр авч налуу үсгээр бичиж, хаалтад зохиогчийн нэр, он, хуудсыг бичнэ. Жишээ нь:

Илт өгүүлэх нэрийг яруу найргийн хэлнээ өргөн дэлгэр хэрэглэж байсан нь зохиолын хэлийг уран тансаг, шим шүлттэй болох гэсэн зорилгоос урган гарсан ажээ. Далайг “сараар арвидагч” гэж нэрлэсэн нь сарны туяанд их далай улам цэлийж харагддагийг онож хэлсэн уран хэллэг юм. Далайг дүрсэлж байгаагийнхаа хувьд энэ нь яруу найргийн хэрэглүүр мөн боловч тодорхой нэг зүйлийг нэрлэж байгаагаараа нэрийн шинж чанартай юм. Энэ бол илт нэрийн нэг онцлог юм. (Сүхбаатар, 2014: 43)

2. Шууд бус эшлэхдээ:

Утга санаагаар эшлэх бол (хураангуйлах, өөрийн үгээр найруулан бичих) зохиогчийн нэрийн ард хаалтад тухайн бүтээлийн оныг бичнэ. Жишээ нь: Академич Д.Цэрэнсодном (2017) энэ тухай “хамгийн бага судлагдсан” хэмээн үзсэн байдаг.

3. Нэг зохиогчтой бүтээлээс эшлэхдээ:

Нэг зохиогчтой, ижил онд хэвлэгдсэн бүтээлүүд бол хэвлэсэн оных нь ард а, б, в гэх мэтчилэн үсгээр дугаарлаж ялгана. Жишээ нь: (Дамдинсүрэн, 1967а: 125, 1967б: 258).

4. Олон зохиогчтой бүтээлээс эшлэхдээ:

2 зохиогчтой бол 2 зохиогчийн нэрийг хоёулыг дурдана. Жишээ нь: (Жамсранжав, Дугарсүрэн нар, 2018: 33).

3 ба түүнээс дээш зохиогчтой бол зөвхөн эхний зохиогчийн нэрийг дурдаж, бусад зохиогчийг “ба бусад” гэсэн үгээр товчилно. Жишээ нь: (Чоймаа ба бусад, 2023: 114).

Олон зохиогчийн бүтээлийг нэг зэрэг эшлэх тохиолдолд он дарааллаар бичнэ. Жишээ нь: (Ринчен, 1964: 17; Цэвэл, 1968: 48; Дамдинсүрэн, 1985: 64).

5. Гадаад хэлээр хэвлэгдсэн бүтээлээс эшлэхдээ:

Агуулгыг монгол хэлээр орчуулж зохиогчийн нэрийг тухайн хэлээр нь бичнэ. Жишээ нь: (Chandra Dass, 1979: 48).

Ном зүйд дараах шаардлагыг баримтална:

Ном зүйн жагсаалтад зөвхөн эш татсан эх сурвалжийг оруулна. Ингэхдээ дугаарлахгүй, монгол ба гадаад хэлээр гэж ангилан, цагаан толгойн үсгийн дарааллаар бичнэ. Үүнд,

Ном

· 1 зохиогчтой бол:

Жишээ нь: Цэвэл. Я, (2013). *Монгол хэлний товч тайлбар толь*, УБ., 1311х. [Tsevel Ya, *Mongol khelnii tovch tailbar toli* [Short explanatory dictionary of the Mongolian language], Ulaanbaatar: 2013]

· 2 зохиогчтой бол:

Жишээ нь: Бүрнээ, Д., Энхтөр, Д. (2004). *Монголын бурхны шашны түүхэн сурвалж*, УБ. [Burnee, D., Enkhtör, D. *Mongolyn burhny shashny tüühen survalj* [Historical sources of Mongolian Buddhism.] Ulaanbaatar, 2004.]

Эмхэтгэл

Эмхэтгэгч бүхий эх сурвалжийг ном зүйд оруулахдаа эмхэтгэгчийн овог, нэрийг дээрх зарчмаар бичих ба ард нь таслалаар зааглан (эмх.) (ред.) (ед.) гэсэн үгийг нэмж оруулна.

Жишээ нь: Мөнхцэцэг, Н., Шинэбаяр, О. (эмх.), (2014). *Монгол нэр томъёо судлал-90*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Munkhtsetseg, N., Shinebayar, O. *Mongol ner tomyo sudlal-90* [Mongolian Terminology Studies-90]. Ulaanbaatar: Soyombo printing. 2014.]

Өгүүлэл:

· 1 зохиогчтой бол: Зохиогчийн нэр, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он). *Өгүүллийн нэр*. Сэтгүүлийн нэр, Сэтгүүлийн гаралтын дугаар (тухайн оны дугаар), Хуудасны дугаар.

Жишээ нь: **Шагдарсүрэн, Ц.** (2008). *Монгол толь бичгийн судлал*, Толь бичиг судлалын асуудалд, УБ., х.19-68. [Shagdarsuren Ts, *Mongol toli bichgiin sudlal* [Study of the Mongolian lexicography], Ulaanbaatar: 2008]

· 2 ба түүнээс дээш зохиогчтой бол: Зохиогчийн нэр, овгийн эхний үсэг томоор., Хоёр дахь зохиогчийн нэр, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он). Өгүүллийн нэр. Сэтгүүллийн нэр, Сэтгүүллийн гаралтын дугаар (тухайн оны дугаар), Хуудасны дугаар.

Батмөнх, С., Эрдэв, Б. (2004). *Техник технологийн нэр томъёог сурах бичигт хэрэглэж буй байдал, түүнийг жигдлэх асуудалд*. Нэр томъёо судлал, 6: 83-88. [Batmunkh, S., Erdev, B. *The Current State of Technical and Technological Term Usages in Textbooks and Its Harmonization*. Ner tomyo sudlal, 2004, 11: 83-88]

· Цахим сүлжээнээс авсан эх сурвалжийг ном зүйд оруулахдаа “Available at” эсвэл “Retrieved from” гэсэн үг бичнэ. “Available at” гэдэг нь судлаач тухайн эх сурвалжийг төлбөртэй авч ашигласан гэсэн санааг илтгэнэ. Энэ тохиолдолд эх сурвалжийн цахим хаягийг тодорхой тусгах шаардлагатай байдаг.

Жишээ нь: Humbley, J. (2009). Accounting for term formation. Terminology Science and Research 20. Available at <http://lipas.uwasa.fi/hut/svenska/iitf/tsr2005/vol20/>. Accessed 15 June 2010.

· “Retrieved” гэдэг нь судлаач интернэтээс авсан эх сурвалжийг үнэ төлбөргүй авч ашигласан гэсэн санааг илтгэнэ.

Жишээ нь: Lai, Gorman Yuan and Liberman (2008) Perception of Disfluency Language Differences and Listener Bias. *Interspeech*. pp. 2345-2348. <http://dx.doi.org/10.1.1.165.6866>. Retrieved from www.ling.upenn.edu/~kgorman/papers/laietal2007.pdf

Зохиогч та бүхэн өгүүллийн стандарт шаардлага болон зохиогчийн эрх, оюуны өмчийн тухай хуулийн заалтыг чанд мөрдөн гүйцэтгэнэ үү.

Холбоо барих: Б.Баяртуяа /9111-8360/

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн
Сурвалж бичиг, төвөд судлалын салбар
2024.03.15